

STUDIA FOLCLORICA
INSTITUTI LINGUAE ET LITTERARUM ACADEMIAE
SCIENTIARUM REIPUBLICAE POPULI MONGOLICI

Tomus X

Fasciculus I-13

АМАН ЗОХИОЛ
СУДЛАЛ

Редактор Д. Цэрэнсодном

Шинжлэх Ухааны Академийн Хэвлэл
Улаанбаатар
1976

STUDIA FOLCLORICA
INSTITUTI LINGUAE ET LITTERARUM ACADEMIAE
SCIENTIARUM REIPUBLICAE POPULI MONGOLICI

Redigit prof. A. Luvsandendev

Олон Улсын Монголч Эрдэмтний
III их хуралд зориулав.

8 M
A-515

7-2
32I-76

STUDIA FOLCLORICA
INSTITUTI LINGUAE ET LITTERARUM ACADEMIAE
SCIENTIARUM REIPUBLICAE POPULI MONGOLICI

Том.Х

Ғас. I2

Х. Сампилдэндэв

"ТОНОГ АВАХ" ЁСНЫ ТАЛААР ТОДРУУЛМААР
ЗАРИМ ЗҮЙЛ

"Монголын нууц товчоо" эртний монголчуудын янз бүрийн ёс, зан заншлын талаар олон сонирхолтой зүйлийн ул мөрийг тусгажээ. Үүний нэг нь "Тоног авах ёс" бөгөөд 187-р зүйлд "...čisutu tonoy abuqči-ba'atud-i jī-sūjū qubiyaju qūrgäldūn yadaba"¹ гэх буюу 195-р зүйлд "tādā jidatu ārāyi jī'uju, čisutu tonoy tonočin üldütü ārā-yi hūldājū unaqa alaju üb tonaq abuqčin uru'ut Mangyut"² гэх мэтээр гардаг. Энд гарч буй čisutu tonaq abuqči, čisutu tonaq tonočin, üb tonaq мэтийн үг хэллэгийг А.Палладий, Л.Лигети, Э.Хэниш зэрэг эрдэмтэд цуст хувцас хунар булаан авагч, цуст зэр зэмсэг, эд агуурс тонон авагч гэсэн утгаар ойлгож байсан билээ. Гэтэл судлагч М.Гаадамба "Хэл зохиол" цуврал номын 5-р бөтийн 5-р дэвтэрт "Монголын нууц товчооны тоног гэдэг үгийн учир" хэмээх өгүүлэл нийтлүүлж "балар эртний монголчуудын дунд баатар эр дайн тулалдаанд дайснаа дарвал ялж дийлсний баримт нотолгоо болгож алагдсан дайсны биеэс /чих, хуруу, толгой хуйх зэрэг/ ямар нэгэн хэсгийг нь огтолж буюу өвчин авдаг заншилтай байсныг заасан үгс болов уу"³ гэж сонин таамаглал хийжээ. Үүний дараа эрдэм шинжилгээний ажилтан Ц.Шагдарсүрэн мөнхүү цуврал номын 8-р бөтийн 9-р дэвтэрт "Монголын нууц товчооны тоног гэдэг үгийн тухай" гэдэг

өгүүлэл хэвлүүлж "монгол болон монголтой төрөл бусад хэлнээ тоног гэдэг үг зөвхөн юмны хэрэгсэл, зэмсэг хувцас гэсэн утгатай л тохиолдож байна. ...тоног гэдэг үг бүр эрт тонож авсан юм, дээрэмдэж авсан юм, хэрэг болгож авсан юм гэсэн утгатай байснаа үгийн утга баяжиж хомстохын ёсоор хувцас хунар, эд агуурс зүүлт чимэг, хэрэгсэл гэсэн утгатай болж тэр утгаараа Монголын нууц товчоонд явж байгаа бололтой" гэж үзжээ.

Ц.шагдарсүрэнгийн өгүүлэлд "дайснаа дарж цустай хувцсыг нь тайлан авч ганзагалаад баруун талдаа еерийн морийг зүүн талдаа дайсны морийг хөтлөн явж" дайнд ялан дийлсний бэлэг тэмдэг болгодог тухай ёс заншил Банзарын Доржийн бүтээлд гардгийг дурдсан нь хайхралгүй өнгөрч болохгүй баримт юм.

Дурдсан хоёр өгүүллийг үзэхэд М.Гаадамбын санал уг үгийг түүхэн цаг үеийн нөхцөл байдал, эртний олон ёс заншилтай нягт холбон үзсэнээрээ, Ц.Шагдарсүрэнгийнх нутгийн аялгууны болон толь бичгийн ноттой баримтанд тулгуурлан хэлснээрээ анхаарал татаж байна.

Зохиолын утга санаа, баатрын дүр төрхийг тодруулахад нэг үг боловч ганцахгүй, учир холбогдолтой байдаг учраас нэг үгийг хоёр өөрөөр тайлбарласан эдгээр саналыг шийдэх нь судалгааны ач холбогдолтой юм. Тэгэхдээ миний бие үүнийг нэг мөр болгон шийдэх гэсэн нь бус харин хожмын судалгаанд өчүүхэн ч атугай санаа сэдлэг өгч юун магад гэж үзээд доорхи саналыг өгүүлж байна.

... I. "Тоног" гэдэг үгийг судлахдаа саланги тусад нь бус харин тухайн өгүүлбэрийн утга,урьд хойтох үгийнх нь харьцаан дунд авч үзэх хэрэгтэй юм. Тэгвэл Монголын нууц товчоонд эл үг "čisutu tonоq üb tonоq гэсэн хоёр янзаар, өөр өөр үгстэй хоршин гарч буй бөгөөд

тоног гэдэг үгийн бичлэг ч гэсэн хоёр өөр буйг анхаарахгүй байж болохгүй. Тэгэхдээ эдгээр үг хэллэг давтагдан гарч буйгаас үзвэл тогтвортой нэр томъёоны байдалтай ажээ. Хоршсон үг болон бичлэгийн ялгаатай байдал нь цаашдаа уг хоёр үгийн утгын ялгааг харуулж байж магадгүй бөгөөд ер нь ч өгүүлбэрийн утгаас үзвэл цуст тоног гэдэг нь алагдсан дайсны хувцас хунар, өв тоног гэдэг нь толгойн хуйх гэсэн өөр өөр утгатай байж болох байна.

Ялангуяа өв тоног хэмээх үгийн хувьд "үлдэгү-эрэ-ийн бүлдэжү" унагажу алажу, үв тонаг абургчин" гэх мэтээр илд жад барьсан дайсныг үлдэн хөөж унаган алдаад ялж дийлсний гэрч болгон хуйхыг нь өвчин хуулж авсныг тэмдэглэсэн утгатай байж болох мэт бөгөөд "үб - гэдэг нь үбчих /өвчих/ гэдэг үгийн язгуур байж магадгүй. Үб тоног абургчин гэдэг нь өвчин хуулж авагчин гэдэг утгатай үг байж болох байна"⁵ гэсэн санал зүйтэй мэт санагдана.

Иймд тоног авах ёс нь зөвхөн хувцас хунар тайлж авах гэсэн ерөөсгөл утгаар бус аль алиныг нь багтаасан өргөн дэлгэр агуулгатай байж болох юм.

2. Түүхэн цаг үеийн дэс дарааллаар авч үзвэл эртний Галл, Скиф хоёр аймагт байсан скальп /буюу ялагдсан дайсны толгойн хуйхыг үстэй нь хуулан авах/ заншилтай төстэй "өв тоног" авах ёс нь овгийн байгууллын үеэс уламжлалтай маш эртний зан үйл юм.

Ер нь аливаа ёс заншил нэгэн хэвдээ байдаг биш түүхэн цаг үеийн нөхцөл байдалтай холбогдон хувьсаар байдаг. Мөн түүхэн нөхцөл солигдоход зарим үйлдэхэд нарийн төвөгтэй ёс заншил хялбарчлагдах, эсвэл огт өөр утга агуулгатай болон хэлбэр нь уламжлагдах ч байдаг. М.Гаадамбын өгүүлэлд дурдсанчлан "Эрийн сайн Дунг-Аража туульд энэ баатар эр хар хавцалтай тулалдан дийлэхдээ түүний гэзгийн боодгийг нь ялан

дийлсний баримт болгон авч" буй нь хуйх хуулан тоног авах ёсны сонин хувьслыг харуулж байна. Иймд түүхэн нөхцөл, хүмүүсийн аж байдал, сэтгэхүйн өөрчлөлтийн дагуу хожим тэр бүрийд ягштал даган мөрдөхөд төвөгтэй хуйх хуулан тоног авах ёс нь хүмүүсийн гээг, гэзгийн боолт, чих зэрэг өөр зүйлээр төлөөлөл болон солигдсон бизээ. Энэхүү хувьсалд хүмүүсийн хүнлэг үзэл санаа, гоо сайхны хүмүүжил нөлөөлсөн нь лавтай. Түүгээр ч үл барам хувийн өмч үүссэн үеэс ялагдсан дайсны хувцас хунар, зэр зэвсэг, морь зэрэг эд хэрэглэлийн зүйлийг ч аван тоног авдаг болж аян дайны олз омгийн шинжтэй ч болсон гэхэд хилсдэхгүй бөгөөд тоног гэдэг үгийн дээрэмдэж авсан юм гэсэн утга нь бүр эртнийх бус харин хожмын үеийн болов уу? Мөн хуйх хуулан тоног авах ёс нь хожмын үед хувьсахдаа аян дайнд ялан дийлсний бэлэгдлийн учир холбогдол нь багасан гэмтэн хэрэгтнийг шийтгэх хууль цаазны утгатай болжээ. М.Гаадамбын өгүүлэлд "Оросын нэг ванг Алтан ордны хаан ордондоо дуудан авчраад бодлогыг нь дагасангүй гэж алж улмаар хуйхыг нь хуулан, толгойг нь жаданд хатгах зэргээр хүүрийг нь хөндлөн доромжилсон" тухай дурдсан нь дайн тулаанд ялан дийлсний бэлэг тэмдэг хараахан бус харин бодлогыг нь зөрчсөн "гэмтнийг" шийтгэж олонд цээрлэл болгох гэсэн хууль цаазны шийтгэлийн учир утгатай юм.

Ийнхүү энэ ёс эхний утгаа гэж цэрэг дайны хүрээнээс хальж монголчуудын аж байдлын зүйлсэд нэвтэрсний жишээ олон билээ.

Захчин ястанд бэр гуйхдаа зуучаар хэлүүлж тохиролцсоныхоо баталгаа болгон хүргэн хүүгийн эцэг өөрөө биеээр очиж

— За хүүхэн маань
Манцуйтай байхад
Танай байлаа

Магнаг өмсөхдөө

Манай боллоо

Хууршгүй хуйхза өгч

Хугаршгүй хадгаа барья гэж хэлдэг

ажээ. Энэ нь хэлсэн үгнээсээ буцаж няцахгүйн тэмдэг болдог бөгөөд хэрэв үгнээсээ няцвал хуйхза хуулуу - лахад бэлэн гэж битүү утгаар андгайлж буй хэрэг юм. Мөн

Хуйхтай толгой хуульд захирагддаг

Хувхай толгой хондод захирагддаг

гэх буку эсвэл

Хуйхтай толгой эвнийх

Хувхай толгой эрлэгийх гэх зэргийн зүйр үг байдаг нь хуйх хуулан тоног авэх ёсны анхны утга нь хувьсан хожим хууль цаазны шийтгэлийн учир холбогдолтой болсныг давхар баталж байна.

З ү ү л т

1. Paul Pelliot, *Histoire secrete des Mongols*, Paris, 1949, p. 64
2. Мөн ном, 70-р тал.
3. М.Гаадамба, "Монголын нууц товчооны тоног гэдэг үгийн учир". Хэл зохиол V боть. V дэвтэр. 1967. 71-р тал .
4. Ц.Шагдарсүрэн, "Монголын нууц товчооны тоног гэдэг үгийн тухай". Хэл зохиол судлал. VIII боть. IX дэвтэр. 1970, 315-р тал.
5. М.Гаадамба, мөн өгүүлэл. 72-р тал.

ГАРЧИГ

I. Эрдэм шинжилгээний өгүүдэл

1. Ш. Гаадамба
Зүйр цэцэн үгийн төрөл зүйлийн тусгай
онцлогийн асуудалд 5
2. Д. Дашдорж
Домогт баатрын тухай түүхэн дуу 24
3. Х. Сампилдэндэв
Аман яруу найрагт өгтлөлыг ашигласан нь 55 .
4. У. Загдсүрэн, Л. Хуралбаатар
Эрдэнийн Галбарвасан мод 69 .
5. Р. Нарантуяа
"Далан худалч бэлэн сэнгэ" үлгэрийн үүсэл
хөгжлийн асуудалд 87

II. Эрдэм шинжилгээний бага хурлын

Илтгэл

1. У. Загдсүрэн
Туульч М. Парчины уран бүтээлийн онцлог 107
2. Х. Лувсанбалдан
Тод үсгийн Хан харангуйн тухай 124
3. Д. Цэрэнсодном
Туульчийн уран бүтээлд холбогдох
шинэ олдвор 132

III. Эрдэм шинжилгээний тэмдэглэл

1. Ц. Дамдинсүрэн
Ардын ерөөлч Чимидийн Жигмид 141
2. Ц. Баярсүрэн
Үхрийн сацал сацах ёсон 157
4. Д. Ёндон
Парчины урын санг тодруулах асуудалд . . 161
5. Х. Сампилдэндэв
"Тоног авах" ёсны талаар тодруулмаар
зарим зүйлс 166

АМАН ЗОХИОЛ СУДЛАЛ

Эрхэлсэн Д. Цэрэнсодном

Техник редактор хийж хуулан бичсэн

М.Хартолгойт, В.Мягмарсүрэн

В-60701, Х.Г.№ За.№ 110

Өрөлтөнд 1976 оны 6-р сард

Хэвлэлтэнд 1976 оны 11-р сард

Цаасны хэмжээ 70 X 108 1/16.

Х.х.11 Х.н.х. 15,4

Хэвлэсэн тоо 1400 хувь

Шинжлэх Ухааны Академийн Хэвлэх үйлдвэр

Улаанбаатар. Нэгдсэн Үндэстний гудамж 19.